



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-уул Дүүргийн Тохижилт Үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/19/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	“Эс Жи Эм Ди-Аудит” ХХК Захирал: Д.Эхбаяр Утас: 70006948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn Аудитын менежер: Д.Насанжаргал Утас: 70006948 Цахим хаяг: nasaa@sgmd-audit.mn Ахлах Аудитор: О.Алтанцэцэг Утас: 70006948 Цахим хаяг: info@sgmd-audit.mn Аудитын шинжээч: Ч.Ням-Очир Утас: 70006948 Цахим хаяг: c.nyamaa@sgmd-audit.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Анх. 03.15 № 589

танай _____-ны № _____-т

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ ОНӨААТҮГ-
ЫН ЗАХИРАЛ В.МӨНХ-ЭРДЭНЭ
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан-Уул Дүүргийн Тохижилт Үйлчилгээний Төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хан-Уул Дүүргийн Тохижилт Үйлчилгээний Төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 9 арга

хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	795,981,606.02	465,441,675.53
1.1.2	Дансны авлага	16,245,488.31	10,350,787.31
1.1.6	Бараа материал	391,896,913.42	689,623,917.42
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,204,124,007.75	1,165,416,380.26
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,443,468,394.22	2,887,113,808.64
1.2.2	Биет бус хөрөнгө	161,777.84	145,777.88
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,443,630,172.06	2,887,259,586.52
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,647,754,179.81	4,052,675,966.78
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	11,314,316.00	20,094,316.00
2.1.1.3	Татварын өр	106,455,149.01	13,303,496.02
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	117,769,465.01	33,397,812.02
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	117,769,465.01	33,397,812.02
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.3.1.	Өмч: - төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.5.	Нэмж төлөгдсөн капитал	1,000,000.00	1,000,000.00
2.3.8.	Эздийн өмчийн бусад хэсэг		1,628,853,000.00
2.3.9.	Хуримтлагдсан ашиг	2,528,984,714.80	2,389,425,154.76
2.3.11.	Эзэмшигчдийн өмчийн дүн	2,529,984,714.80	4,019,278,154.76
2.4	ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	2,647,754,179.81	4,052,675,966.78

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,710,740,799.16	6,289,360,518.00
2	Борлуулалтын өртөг		41,500,000.00
3	Нийт ашиг (алдагдал)	6,710,740,799.16	6,247,860,518.00
5	Хүүний орлого		3,123,159.53
8	Бусад орлого		15,465,600.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,779,224,269.19	6,404,462,277.58
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(247,504,553.52)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	684,011,976.45	(138,013,000.05)
19	Орлогын татварын зардал	93,151,652.99	1,546,559.99
20	Татварын дараах ашиг (алдагдал)	590,860,323.46	(139,559,560.04)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	590,860,323.46	(139,559,560.04)
24	Орлогын нийт дүн	590,860,323.46	(139,559,560.04)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00		1,938,124,391.34	1,939,124,391.34
3	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	-	1,938,124,391.34	1,939,124,391.34
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			590,860,323.46	590,860,323.46
9	2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.00		2,528,984,714.80	2,529,984,714.80
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(139,559,560.04)	(139,559,560.04)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	1,628,853,000.00	-	1,628,853,000.00
15	Зарласан ногдол ашиг				-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
17	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.00	1,628,853,000.00	2,389,425,154.76	4,019,278,154.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	5,560,445,241.00	6,292,483,677.53
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	2,108,554,444.00	1,955,227,997.53
	Татаас санхүүжилтийн орлого	3,451,890,797.00	4,337,255,680.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	5,657,803,428.07	6,495,507,990.02
	Ажиллагчдад төлсөн	2,022,838,600.33	2,197,090,750.64
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	641,656,124.51	699,372,047.34

Хан-уул Дүүргийн Тохижилт Үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Бараа материал худалдан авахад төлсөн	34,291,200.00	36,886,400.00
	Ашиглалтын зардалд төлсөн	102,354,587.55	114,523,701.74
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	224,686,905.00	119,793,000.00
	Татварын байгууллагад төлсөн	239,289,639.59	317,061,278.98
	Даатгалын төлбөрт төлсөн	40,004,133.00	12,225,817.00
	Бусад мөнгөн зарлага	2,352,682,238.09	2,998,554,994.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(97,358,187.07)	(203,024,312.49)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	61,190,680.00	127,515,618.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	61,190,680.00	127,515,618.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(61,190,680.00)	(127,515,618.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(158,548,867.07)	(330,539,930.49)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	954,530,473.09	795,981,606.02
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	795,981,606.02	465,441,675.53

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны биелэлт	2023 оны зорилт	2023 оны биелэлт	Зөрүү	Хувь	
1	Орлого	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	3,451,890.80	3,451,890.8	4,337,255.7	(885,364.8)	125.6
		Борлуулалтын орлого	2,108,364.44	2,108,364.4	1,955,228.0	153,136.4	92.7
		Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,150,485.56	-	15,465.6	(15,465.6)	-
		Нийт орлого	6,710,740.80	5,560,255.2	6,307,949.3	747,694.0	113.4
2	Зардал	ББӨртөг	-	-	-	-	-
		Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,512,067.09	2,512,067.09	2,731,278.30	(219,211.21)	108.7
		Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	361,939.13	361,939.13	393,223.61	(31,284.49)	108.6
		Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,891.19	100,891.19	114,523.70	(13,632.51)	113.5
		Бичиг хэргийн зардал	5,232.44	5,232.44	3,499.07	1,733.37	66.8
		Тээвэр, шатахууны зардал	510,786.44	510,786.44	457,271.04	53,515.40	89.5
		Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,026.74	13,026.74	14,433.98	(1,407.24)	110.8
		Ном, хэвлэлийн зардал	-	-	-	-	-
		Хог хаядал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	289,710.00	889,710.00	808,587.99	81,122.02	90.9
Бага үнэтэй, түргэн эдэгдэх,	12,487.65	12,487.65	16,968.86	(4,481.21)	135.9		

Хан-уул Дүүргийн Тохжилт Үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

ахуйн эд зүйлс					
Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	257,242.08	257,242.08	131,037.91	126,204.17	50.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	159,259.93	159,259.93	108,531.84	50,728.08	68.1
Багаж, техник, хэрэгсэл	3,808.10	3,808.10	1,606.30	2,201.80	42.2
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	57,047.26	57,047.26	42,679.72	14,367.54	74.8
Тохжилт /урсгал засвар/	973,290.05	973,290.05	899,316.28	73,973.76	92.4
Томилолт, зочны зардал	-	-	7,257.00	(7,257.00)	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,205.80	102,205.80	150,595.11	(48,389.31)	147.3
Даатгалын үйлчилгээ	39,408.65	39,408.65	11,754.08	27,654.57	29.8
Тээврийн хэрэгслийн татвар, оношлогоо	861.10	861.10	495.00	366.10	57.5
Газрын төлбөр	-	-	1,039.66	(1,039.66)	
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000.00	7,000.00	7,000.00	-	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	228.90	228.90	1,032.66	-	451.1
Хүүний төлбөрт төлсөн -ТӨҮГ	-	-	-	-	
Татварын байгууллагад төлсөн	8,606.28	8,606.28	6,544.39	2,061.89	76.0
Бусад мөнгөн зарлага	11,322.89	11,322.89	19,674.16	(8,351.27)	173.8
Бараа үйлчилгээний бусад зардал	130,717.10	130,717.10	193,072.42	(62,355.32)	147.7
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	18,983.00	18,983.00	-	18,983.00	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	194,219.47	394,219.47	312,739.20	81,480.27	79.3
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	-	-	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,883.00	8,883.00	11,800.00	(2,917.00)	132.8
Нийт зардал	5,779,224.27	6,579,224.27	6,445,962.28	133,261.99	98.0
3 Татварын өмнөх ашиг /алдагдал/	931,516.53	131,516.53	(138,013.00)	(6496.47)	104.9
4 Татварын зардал	93,151.65	13,151.65	-	13,151.65	-
5 Татварын дараах ашиг (алдагдал)	838,364.88	118,364.88	(138,013.00)	(19,648.12)	116.6
6 Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	1.16	1.02	0.98		95.9
7 Авлага	63,738.56	16,245.49	10,350.79	5,894.70	63.7
8 Өглөг	35,363.20	104,617.81	20,094.32	84,523.50	19.2
9 Хөрөнгө оруулалт	250,000.00	200,000.00	127,515.62	72,484.38	63.8

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 80,772.2 мянган төгрөгийн 7 зөрчил¹ илэрснээс, 74,772.2 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6,000.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд харилцах данснаас гэрээний дагуу нэр бүхий иргэний хувийн дансанд цахилгааны төлбөр, ажлын байрны түрээс гэсэн утгаар 41,594.1 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Гэрээг Нийслэлийн өмчийн харилцааны газраар батлуулаагүй.	1	41,594.1			1	41,594.1		
Авлагын дансны насжилтын тайлан гаргаагүй, дансны авлага, өглөг 13,945.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	13,945.0			1	13,945.1		
Тайлант хугацаанд нэг бүр нь 3000 төгрөгийн үнэтэй 2000 ширхэг нийт 6,000.0 мянган төгрөгийн үнэтэй Зөвлөмж (НБ)-ийг тэрбум мод гэсэн зориулалтаар бусад хангамжийн материал данснаас зарлагдсан байна. Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	1	6,000.0					1	6,000.0
Дүүргийн засаг даргын захирамжаар хуваарилсан хөрөнгөөр бий болсон хүлэмжийн сайжруулалт, төмөр хашаа зэрэг хөрөнгүүдийг хөрөнгөөр бүртгээгүй, зардалд бүртгэсэн байна.	1	0.0			1	0.0		
Түрээсийн автомашинаар жолооч зам тээврийн осол гаргаж иргэдэд учруулсан хохирол 19,233.1 мянган төгрөгийг шүүхийн шийдвэрээр төлсөн, авлага үүсгэж бүртгээгүй бөгөөд “Хог хаягдлыг зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал” (210405) зардлын дансанд шууд тусгасан байна.	1	19,233.1			1	19,233.1		
Тус төв нь ажилчдаа ажлын 6 өдөр ажиллуулдаг бөгөөд бүх нийтийн амралтын өдөр ажиллуулсан цалин тооцохдоо хуулийн дагуу илүү цагийн нэмэгдэл тооцохгүй ажлын өдөртэй адил тооцож олгосон байна.	1	0.0					1	0.0
Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгүүд байна.	1	0.0					1	0.0
Дүн	7	80,772.2			4	74,772.3	3	6,000.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийслэлийн засаг даргын А19 захирамжийн хүрээнд олгосон хөрөнгө болох 120,080.0 мянган төгрөгөөр ногооны үр худалдан авахдаа тендер шалгаруулалтгүй худалдан авсан. Мөн тайлант хугацаанд зохион байгуулсан тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулаагүй, хувь хүн болон аж ахуйн нэгж байгууллагаас түрээсээр ашиглаж байгаа тээврийн хэрэгсэлд сонгон шалгаруулалт явуулаагүй байна.	1	120,080.0			1	120,080.0		
Дүн	1	120,080.0			1	120,080.0		
Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил								
Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах цэнхэр дэвсгэртэй дугаараар солиогүй байна.	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0			-	-	1	0.0
Нийт дүн	2	120,080.0			1	120,080.0	1	0.0